21	УРСГАЛ ЗАРДАЛ		60,637.34	-60,637.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		54,831.28	-54,831.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,000.00	-2,000.00
210101	Үндсэн цалин		2,000.00	-2,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,803.27	-2,803.27
210401	Бичиг хэрэг		217.30	-217.30
210402	Тээвэр, шатахуун		1,847.67	-1,847.67
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		144.00	-144.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		594.30	-594.30
2105	Нормативт зардал		14,252.53	-14,252.53
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		12,712.53	-12,712.53
210502	Хоол, хүнс		1,540.00	-1,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,570.00	-4,570.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,795.00	-1,795.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		840.00	-840.00
210604	Урсгал засвар		1,935.00	-1,935.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		26,785.49	-26,785.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		26,785.49	-26,785.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,420.00	-4,420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,420.00	-4,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,806.05	-5,806.05
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		5,806.05	-5,806.05
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		5,806.05	-5,806.05
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		60,637.34	-60,637.34

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		60,637.34	-60,637.34
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,867.00	-10,867.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		49,770.34	-49,770.34

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Мөнхдаваа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 09-өөс 2021 оны 03 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг гүйцэтгэв.

Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 5/114 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн бүрэн эрх:

Өргөн сумын ТТЗ-ийн бүрэн эрхийг “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан байна. Үүнд:

1. Баг, хорооны Засаг даргын ажлыг чиглүүлэн удирдах;
2. Сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх
4. Эрх бүхий байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд заасны дагуу эдэлбэр газар олгох;
5. Албан татвар, төлбөр, хураамж хураах, зохих төсөвт шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх арга хэмжээ авах;
6. Нутаг дэвсгэрийнхээ үйлчилгээний байгууллагуудын эрүүл ахуй, ариун цэврийн байдалд хяналт тавьж, үйлчилгээний цагийн хуваарь тогтоох;
7. Хот, тосгоны иргэдийг цэвэр усаар хангах, хог хаягдал, бохир ус зайлуулах, цэвэрлэх, мод, бут, сөөг, жимсний мод тарьж ургуулах, тохижуулах, гудамж талбайг гэрэлтүүлэх, үер усны хамгаалалт, далан суваг барих арга хэмжээ авах, түүнчлэн харьяалах нутаг дэвсгэрт нь барилга байгууламж барих, зам, холбооны шугам өөрчлөхөд оршин суугчдын санал авч шийдвэрлэх;
8. Хууль тогтоомжид заасан бол тухайн нутаг дэвсгэр дэх төсвийн байгууллагын ажилтныг холбогдох дээд байгууллагын удирдлагатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;
9. Хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуулийн 64.4, 64.5-д заасан журмын дагуу холбогдох байгууллагад хүргүүлэх;
10. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

Тус сум 2020 оны “Хөдөөгийн хөгжлийг дэмжих жил” болгон зорилт, арга хэмжээг төлөвлөн ,зохион байгуулсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Өргөн сумын ТТЗ нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд сумын үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Өргөн сумын ТТЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад “Дунд” гэж үзлээ.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,007.3 сая төгрөгийн 1 хувь буюу 20.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,841.9 сая төгрөгийн 1 хувь 28.4 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлтийн үе шатанд тогтоосон суурь үзүүлэлт, хувь хэмжээг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 70.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 136.8 сая төгрөг болж, 60.1 сая төгрөгөөр өссөн.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	70.8	136.8	60.1	100
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	70,8	136.8	60.1	100

Эх сурвалж Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 75.6 сая төгрөг ОНХС-ийн дансанд, 23.0 сая төгрөг СХС-ийн дансанд, 13.8 сая төгрөг НСС-ийн дансанд, 5.8 сая төгрөг сумын ерөнхий орлогын дансанд нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлэг, 18.6 сая төгрөг төсөвт байгууллагуудын ахмадын сангийн дансанд байршиж байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 239.7 сая төгрөгөөс 219.5 сая төгрөг болж 20.2 сая

төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.2	51.5	51.3
Зээлийн хүүгийн авлага		0.9	0.9
Бусад авлага	73.7	6.4	-67.3
Зээлийн авлага	165.8	160.7	-5.1
Дүн	239.7	219.5	20.2

Эх сурвалж Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Авлагын дансны үлдэгдэл 63.6 сая төгрөг 1 жил, 56.1 сая төгрөг 1-2 жил, 0.2 сая төгрөг 3-4 жил, 11.5 сая төгрөг 4-5 жил, 93.6 сая төгрөг 5-аас дээш жилийн насжилттай байна. Авлагын 4-5 болон 5-аас дээш жилийн насжилттай авлага нь сум хөгжүүлэх сангийн зээлдэгдэгч нарын зээлийн авлагын үлдэгдэл байна. Харин 1 хүртэл жилийн насжилттай авлага нь тайлант оны жилийн эцэст нэмэлт санхүүжилтийн данснаас буцаан төвлөрүүлсэн шилжүүлгийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Ерөнхий боловсролын сургууль нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан авлагатай байгаа ба энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн зарчмыг баримталж ажиллагаагүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 283.9 сая төгрөгөөс 309.0 сая төгрөг болж 25.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	49.9	70.0	20.1
Хангамжийн материал	174.6	176.6	18.6
Мал амьтад	59.3	62.5	3.2
Дүн	283.9	309.0	25.1

Эх сурвалж Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бараа материалын үлдэгдэлд тайлант онд 148.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 8.4 сая төгрөгийн бараа материалыг хандиваар хүлээн авч, 171.0 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 5.4 сая төгрөгийн бараа материал акталж устгасан байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,586.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,593.5 сая төгрөг болж 1,006.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,466.3	5,467.1	1,000.9
Биет бус хөрөнгө	120.7	126.3	5.6
Дүн	4,586.9	5,593.5	1,006.5

Эх сурвалж Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 23.1 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 3.6 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,377.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 3.4 сая, худалдсан 29.7 сая, акталсан болон бусад байдлаар 133.1 сая, акталсан 54.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын Засаг даргын тамгын газар 11,951.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данснаас хассан боловч устгалын баримт үйлдээгүй байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 72.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 46.8 болж, 26.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	72.8	46.8	-26.0	100
Ажилчидтай холбогдсон өглөг	0.2	1.1	0.9	-3.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	6.7	44.4	37.7	-145
Бусад өглөг	65.9	1.3	-64.6	248
Нийт дүн	72.8	46.8	-26.0	100

Эх сурвалж Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 5.8 сая төгрөгийн төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн буцаан төвлөрүүлэх шилжүүлгийн өглөг, 0.3 сая төгрөг сумын ЕБС-ийн ажилчны шүүхийн шийдвэрийн буцаан олголтын илүү суутгасан, 0.05 сая төгрөг түрээсийн орлогын 50 хувийн төвлөрүүлээгүй үлдэгдэл, 0.6 сая төгрөг сумын Соёлын төвийн татварын хөнгөлөлтийн зөрүүгээс үүссэн ажилчидтай холбоотой өглөг, 42.1 сая төгрөгийн сумын Соёлын төвийн түлш халаалтын өглөг, сумын Засаг даргын тамын газрын 0.5 сая төгрөгийн орон сууц түрээслүүлсний төлбөрийн өглөг, 0.1 сая төгрөгийг илүү суутгалыг ажилчдад олгоогүй үлдэгдэл, 1.5 сая төгрөг сумын ЭМТ-ийн бараа үйлчилгээний бусад зардлын өглөг, 0.5 сая төгрөг ажилчидтай холбоотой болон бараа үйлчилгээний бусад зардлын өглөг байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,108.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,212.1 сая төгрөг болж, 1,103.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/-	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,574.60	2,574.60	0.00	0%
Хуримтлагдсан үр дүн	1,081.60	2,185.10	1,103.50	50%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,452.30	1,452.30	0.00	0%
Дүн	5,108.5	6,212.1	1,103.6	100%

Эх сурвалж Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Хуримтлагдсан үр дүн 2,185.1 сая төгрөг болж сая төгрөг болж 1,103.5 сая төгрөгөөр өссөн байна.

3.5.10 Орлогын данс

Тайлант онд нийт үйл ажиллагааны мөнгөн орлого 2,651.6 сая төгрөгөөс татварын орлого 56.9 сая төгрөг, татварын бус орлого 41.5 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 2,553.2 сая төгрөг төвлөрсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ЗДТГ:

- Түрээсийн орлогын төлөвлөгөөг дутуу төлөвлөсөн;
- Туслах аж ахуйгаас орсон орлогын тооцоо бодоогүй;

3.5.11 Зардлын данс

Тайлант онд нийт зардлын дүн 2,392.7 сая төгрөг байгаагаас бараа, ажил үйлчилгээний зардалд 1,750.5 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 642.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ЗДТГ:

- Тайлант онд 2 хүнд ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхиулан 182.2 мянган төгрөгийг олгосон;
- Тээврийн хэрэгслийн татварын зардлаас жолоочийн торгууль болох 64.0 мянган төгрөгийг шилжүүлсэн;
- Засаг даргын орлогчид ажил хавсран ажилласны нэмэгдэл 30 хувь олгосон;
- Үндсэн цалингийн зардлаас хүүхэд асрах чөлөөтэй 2 хүний НДШ-ийг төлсөн;

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2/06 дугаар тогтоолд зааснаар Өргөн сумын ТТЗ нь тайлант онд 47.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 67.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 144 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

№	Орлогын төрөл	2020 оны 12 сар тодотгол	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Үйл ажиллагааны орлогын албан татвар	1,000.0	821.1	- 178.9	82.1
2	Бусад татвар	13,000.0	25,523.8	12,523.8	196.3
3	Бууны татвар	1,770.0	1,050.0	- 720.0	59.3
4	Улсын тэмдэгтийн хураамж	1,700.0	1,799.9	99.9	105.9

5	Хог хаягдал үйлчилгээний хураамж	5,000.0	3,180.6	- 1,819.4	63.6
6	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4,975.2	7,819.9	2,844.7	157.2
7	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	4,000.0	5,545.3	1,545.3	138.6
8	Хадгаламжийн хүүгийн орлого	12,982.5	13,516.3	533.8	104.1
9	Хөрөнгө борлуулсны орлого	2,590.0	3,149.8	559.8	121.6
10	Хүү торгуулийн орлого	100.0	5,570.0	5,470.0	5,570.0
Нийт орлого		47,117.7	67,976.7	20,859.0	144.3

- Үйл ажиллагааны орлого 17.9 хувиар тасарсан нь тайлант оны худалдан авалттай холбоотой, бууны татвар 40.7 хувиар тасарсан нь буу эзэмшигч иргэд бууг шилжүүлсэн, зарсан боловч хасалт хийгдээгүйтэй холбоотой, хог хаягдал үйлчилгээний хураамж 36.4 хувиар тасарсан нь айл өрхүүд хураамжийг төлөөгүйтэй холбоотой байна.
- Бусад татвар 96.3 хувиар давсан нь тайлант оны худалдан авалттай холбоотой, улсын тэмдэгтийн хураамж нотариатын үйлчилгээ өссөнтэй холбоотой, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 57.2 хувиар давсан нь гэрээ байгуулсан ААНБ ашигт малтмалын хэрэгцээ шаардлага төлөвлөснөөс илүү байсантай холбоотойгоор, төсөвт байгууллагын өөрийн орлого 38.6 хувиар давсан нь сумын ЗДТГ-ын орон сууцны түрээсийн орлого болон түүхий эд борлуулсны орлого бүрдүүлснээр, хадгаламжийн хүүгийн орлого 4.1 хувиар давсан нь арилжааны банк дахь хадгаламжийн хэмжээ их байсантай холбоотой, хөрөнгө борлуулсны орлого 21.6 хувиар давсан нь тайлант онд иргэдийн хөрөнгийн худалдан авалт их байсантай холбоотой, хүү торгуулийн орлого төлөвлөснөөс хэт давсан нь сумын цагдаа торгуулийн пос машинтай болсноор торгуулийн орлогыг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг аудитын явцад ирүүлээгүй байна. Энэ талаар тодруулахад ТТЗ-ийн төсвийг төсөл боловсруулагддаггүй гэсэн тайлбарыг өгч байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 2,087.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,862.2 сая төгрөгийг урсгал зардалд, 225.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,241.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 784.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20.3 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 41.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,187.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 725.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20.3 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 23.7 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, нийт 1,956.6 сая төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 18.6 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 18.1 сая төгрөгөөр давсан нь сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт, нөхөн сэргээлтийн сангийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 5.0 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 1.5 сая төгрөгөөр давсан сумын ЗДТГ-ын түрээсийн орлого болон түүхий эд борлуулсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,902.6 сая төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь боловсролын салбарын үйл ажиллагааг хязгаарласнаар зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдэл 18.5 сая төгрөгийг улсын төсөвт, 18.2 сая төгрөг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс орон нутгийн төсөвт, нийт 36.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 52.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 17.7 сая төгрөг, нийт 69.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 63.7 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 6.2 сая төгрөгийг сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 175 мэдээллээс 164 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийн хугацаа болоогүй, 7 мэдээллийг хугацаа хоцроож, 4 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй байна. Мэдээлээгүй мэдээлэл нь сумын Засаг даргын 4 захирамж байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчил арилгах 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага	2		2				100
Зөвлөмж	1				1		0
Нийт	3		2		1		66.7

Өмнөх аудитаар Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 1 иргэний асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн эцэслэн шийдвэрлүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн байна. Зөвлөмжийн дагуу Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн эвлэрүүлэн зуучлахад шилжүүлсэн боловч цар тахал гарснаар одоог хүртэл тус байгууллагатай гэрээ байгуулаагүй байна. Гэрээг 2021 оны 4 сарын 1-ний дотор байгуулах тухай албан бичгийг манай байгууллагад ирүүлсэн байна.

Мөн сумын ЗДТГ-т өмнөх оны аудитаар 1,558.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон боловч хэрэгжилт 61.4 хувьтай байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, орон нутгийн тусгайн сангийн нийт 3 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 3 сан түүврээр хамрагдсан, 1 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3 дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 88.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 21.9 сая төгрөгийн 9 алдааг аудитын явцад залруулж, 0.2 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 65.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 1.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Өргөн сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл	Аудитын код: ДГА-2021/13/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Өргөн сумын ТТЗ	мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	ЗДТГ: Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхцуулан 2 ажилтанд 128.2 мянган төгрөгийг олгосон.	128.2	Төлбөрийн акт тогтоох	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
2	ЗДТГ: Тээврийн хэрэгслийн татварын зардлаас жолоочийн торгууль төлсөн.	64.0	Төлбөрийн акт тогтоох	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
3	ЗДТГ: Засаг даргын орлогч М.Түмэнбаярт хавсран ажилласны нэмэгдэл 30 хувь олгосон.	2,822.6	Албан шаардлага өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
4	ЗДТГ: Өмнөх онд 1,558.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилт 61.4 хувьтай байна.		Албан шаардлага өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
5	ЗДТГ: Үндсэн цалингийн зардлаас хүүхэд асрах чөлөөтэй 2 хүний НДШ төлсөн.	803.5	Албан шаардлага өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
6	ЗДТГ: Түрээсийн орлогын төлөвлөгөөг дутуу төлөвлөсөн.		Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
7	ЗДТГ: Нийт 11,951.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, данс бүртгэлээс хассан боловч устгалын баримт үйлдээгүй.		Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
8	ЗДТГ: Туслах аж ахуйгаас орсон орлогын тооцоо бодоогүй.	1000.0	Зөвлөмж өгөх	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
9	ЗДТГ: Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 450.0 мянган төгрөгийн малын үнэ, 308.0 мянган төгрөгийн	758.0	Залруулсан.	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс

	төхөөрөмжийн үнийг шууд зардалд бүртгэснийг бараа материалын орлогоор бүртгэж залруулсан.				
10	ЗДТГ: Түрээсийн орлогын 50 хувийг өглөгөөр тусгасан бөгөөд 31.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг өглөгөөр нэмж бүртгэсэн.	31.0	Залруулсан.	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
11	ЗДТГ: Түрээсийн авлага 997.0 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлагаар бүртгэснийг залруулсан.	997.0	Залруулсан.	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
12	ЗДТГ: Эд хариуцагч тайлангаа НББ-ээс 986.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.	986.2	Залруулсан.	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
13	ЗДТГ: Түрээсийн авлага 38.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг авлагаар нэмж бүртгүүлсэн.	38.0	Залруулсан.	ЗДТГ-ын дарга Нягтлан бодогч	О.Цасанцэцэг М.Отгонтөгс
14	ЕБС: Тайлант хугацаанд авлагатай гарсан.		Зөвлөмж өгөх	Захирал	С.Төгсжаргал
15	Элэгдлээрээ өртгөө нөхсөн, актласан хөрөнгийг данснаас хасахдаа хуримтлагдсан элэгдлийг бууруулалгүй зардлаар хассан бичилт хийсэн байна.	16,192.1	Залруулав	Нягтлан бодогч	С. Баатарсүрэн
17	ЭМТ: Мөнгөн гүйлгээний тайлангийн цалин, НДШ, томилолтын зардлаас бусад зардалд и-баримтыг тулган баталгаажууллаа.		Зөвлөмж өгөх	Дарга, Нягтлан бодогч	С.Адъяасүрэн, Б.Сайханбаяр
18	ОНХС: Огт хийгдээгүй ажлыг бүртгэл тайланд өглөгөөр хасах тэмдэгтэйгээр тусгасан байна.		Залруулав	Засаг дарга Нягтлан бодогч	Ц.Мөнхдаваа М.Отгонтөгс
19	СХС: Үр дүнгийн тайланд орлогыг дутуу бүртгэсэн байна.	2000.0	Залруулав	Засаг дарга Нягтлан бодогч	Ц.Мөнхдаваа М.Отгонтөгс
20	СХС: Санхүүгийн тайланд зээлийн хүүгийн авлагыг огт тусгаагүй байна.	898.3	Залруулав	Засаг дарга Нягтлан бодогч	Ц.Мөнхдаваа М.Отгонтөгс
21	СХС: 2020.12.31-ний байдлаар зээлдэгч нартай өр авлагын тооцоо нийлээгүй байна.	61,763.3	Албан шаардлага өгөх	Засаг дарга Нягтлан бодогч	Ц.Мөнхдаваа М.Отгонтөгс
	Дүн	88,48262			